

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ
ТАЛААРХ ЁС ЗҮЙ, ДЭГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 08 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Н.Батсүмбэрэл, П.Сайнзориг, Х.Тэмүүжин, Д.Цогтбаатар, Д.Энхтуяа нараас 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Ёс зүй, дэгийн байнгын хороо 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа Улсын Их Хурлын анхдугаар чуулганы үеэр Улсын Их Хурлын гишүүдээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг өөрчилж, өөрсдөө тогтоох санал гарч байсныг дурдан асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал уг хуульд тодорхой хугацаа зааж өгөх, Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл тухайн хуулийг нэг удаагийн шинжтэйгээр баталж мөрдүүлэх нь зүйтэй гэсэн саналыг тус тус хэлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Ёс зүй, дэгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЁС ЗҮЙ, ДЭГИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**

Б.БАЯРБААТАР



ТҮСЭГ 3781 302205132 0087184